

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, МОНГОЛ УЛСЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ

№ 4А, 2025 / 01-34

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр /цаашид "НҮБХХ" гэх/ болон Монгол Улсын Чингэлтэй Дүүргийн Засаг даргын Тамгын газар /цаашид "ЧДЗДТГ" гэх/ нь хамтдаа Монгол Улсад "Нарны Илч" төслийн баримт бичигт тусгайлан тусгасан, мэдээлэл болгон хуваалцсан төсөл /цаашид "төсөл" гэх/-ийг хамтран хэрэгжүүлэхээр тохиролцсоны ҮНДСЭН ДЭЭР

ЧДЗДТГ нь тус төслийг хамтран санхүүжүүлэх зарчмын хүрээнд өөрт оногдох хувь /цаашид "ЧДЗДТГ-т оногдох хувь" гэх/-ийг НҮБХХ-д хүлээлгэн өгснөөр Гэр хороололд сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг дэмжихэд шаардагдах хөрөнгийг өсгөн нэмэгдүүлэхэд бэлэн байгаагаа НҮБХХ-т мэдэгдсэний ҮНДСЭН ДЭЭР

Мөн, ЧДЗДТГ-т оногдох хувиар санхүүжүүлэх төсөл тус бүрийн хэрэгжүүлэгч (цаашид "хэрэгжүүлэгч" гэх)-ийг шалгаруулан томилох үүргийг НҮБХХ хариуцан ажиллах болсны ҮНДСЭН ДЭЭР

НҮБХХ болон Чингэлтэй Дүүргийн Засаг даргын Тамгын газар дараах зүйлс дээр харилцан тохиролцов:

1 дүгээр зүйл

1. ЧДЗДТГ энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар 300 000 [гурван зуун мянган ам.доллартай тэнцэх хэмжээний 1,028,400,000 [нэг тэрбум хорин найман сая дөрвөн зуун мянга] төгрөгийг НҮБХХ-ийн мэдэлд шилжүүлнэ. 2025 оны 2-р сарын 1-ны өдрийн НҮБ-ын үйл ажиллагааны долларын ханшаар тооцоолов.
2. ЧДЗДТГ дор дурдсан төлбөрийн хуваарийн дагуу ЧДЗДТГ-д оногдох хувийг тухайн өдрийн ханшаар шилжүүлнэ.

**Худалдаа Хөгжлийн Банк
Энхтайван салбар
404001574 төгрөгийн данс
UNDP НҮБХХ**

Шилжүүлэх өдөр

(а) 2025 оны 03 дугаар сарын 15

Дүн (заасан валют)

1,028,400,000 төгрөг

3. ЧДЗДТГ-т оногдох хувийг НҮБХХ-д шилжүүлсний дараа ЧДЗДТГ нь contributions@undp.org цахим шуудангийн хаягаар дараах мэдээллийг мөнгөн гуйвуулгын баримтын хамт илгээнэ: "ЧДЗДТГ, НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар, "Нарны Илч" төсөл. /Дээрх мэдээлэл мөн мөнгөн гуйвуулгын утга хэсэгт тусгагдсан байна/.
4. АНУ-ын доллароос өөр валютаар шилжүүлэг хийгдсэн тохиолдолд төлбөрийн дүнг төлбөр хийх өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй НҮБ-ын ханшийг ашиглан



хөрвүүлнэ. Шилжүүлсэн дүнг бүрэн ашиглаж дуусахаас өмнө НҮБ-ын ханшид өөрчлөлт гарсан тохиолдолд НҮБХХ нь тухайн үед хадгалагдаж байгаа үлдэгдлийг тухайн өдрийн ханшаар тооцож зөрүүг зохих ёсоор баримтжуулна. Хэрэв ханшийн зөрүүнээс шалтгаалан мөнгөний үлдэгдэл нь цаашдын үйл ажиллагаанд хүрэлцэхээргүй болсон тохиолдолд НҮБХХ нь ЧДЗДТГ-аас нэмэлт санхүүжилт олгох боломжтой эсэхийг тодруулахаар холбогдоно. Хэрэв нэмэлт санхүүжилт хийгдэх боломжгүй бол НҮБХХ "Нарны Илч" төслийн хүрээнд үзүүлэх тусламжийн хэмжээг бууруулах, түр зогсоох, бүрэн цуцлах хүртэл арга хэмжээ авна.

5. Төслийн төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө дээрх төлбөрийн хуваарьт заагдсан ЧДЗДТГ-т оногдох хувийг шилжүүлнэ. Төслийн хэрэгжилтийн явцтай уялдуулан төлбөрийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулж болно. НҮБХХ нь төслийн хүрээнд гарсан ямар нэгэн (валютын ханшийн хэлбэлзэл болон бусад) алдагдлыг хариуцахгүй болно. Эдгээр алдагдлыг төслийн хөрөнгөөс гаргах болохыг талууд харилцан хүлээн зөвшөөрч байна.
6. Санхүүгийн бүх бичиг баримт, зарцуулалтын тайланг АНУ-ын доллароор илэрхийлнэ.
7. НҮБХХ-ийн хувьд бүрэн хөрвөх боломжтой, ашиглахад хялбар байх бөгөөд дээрх 6 дугаар заалтад нийцсэн тохиолдолд АНУ-ын доллароос өөр мөнгөн тэмдэгтээр ЧДЗДТГ-т оногдох хувийг хүлээн авах болно. Шилжүүлэх мөнгөн тэмдэгтийг зөвхөн НҮБХХ-тэй тохиролцсоны үндсэн дээр өөрчилнө.

2 дугаар зүйл

1. Бусад байгууллагын хөрөнгөөр хэрэгжих төслийн санхүүжилтэд НҮБХХ-ийн төв болон бүсийн оффисууд, суурин төлөөлөгчийн газруудын шууд бус зардлыг нөхөх тухай НҮБХХ-ийн Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргасан захирамж, зааварчилгааны дагуу тус төслийн ЧДЗДТГ-т оногдох хувиас тодорхой шимтгэл авна. Энэхүү шимтгэл нь тус төслийн хүрээнд ЧДЗДТГ-т оногдох хувиас 5%-тай тэнцэх хэмжээнд байх болно. Үүнээс гадна энэхүү төслийн хэрэгжилтийн хүрээнд гарах зардлыг, түүн дотор хэрэгжүүлэгчийн гаргах төслийн хэрэгжилттэй шууд холбоотой зардлыг төслийн төсөвт тусгаж, төслөөс санхүүжүүлнэ.
2. Төслийн үйл ажиллагааны төсөв болон холбогдох зардлууд, шимтгэлүүдийн нийт мөнгөн дүн нь энэхүү гэрээний дагуу тус төсөлд хуваарилагдсан нийт мөнгөн дүн болон бусад эх үүсвэрээс ирэх мөнгөн дүнгээс хэтрэхгүй байна.

3 дугаар зүйл

1. Төслийн хэрэгжилтэд зориулагдсан ЧДЗДТГ-т оногдох хувийг НҮБХХ-ийн холбогдох дүрэм, журам, дотоод бодлого болон үйл ажиллагааны дэгийн дагуу НҮБХХ захиран зарцуулна.
2. Төслийн удирдлага зохицуулалт болон зардлыг нь НҮБХХ-ийн дүрэм, журам, дотоод бодлого болон үйл ажиллагааны дэг ёсоор, мөн шаардлагатай

тохиолдолд хэрэгжүүлэгчийн дүрэм, журам, дотоод бодлого болон үйл ажиллагааны дэгийн дагуу зохицуулна.

4 дүгээр зүйл

1. НҮБХХ-ын болон хэрэгжүүлэгчийн хүлээх эрх, үүрэг нь энэхүү гэрээ болон төслийн бусад баримт бичгийн дагуу, дээрх 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад заасан төлбөрийн хуваарийн хүрээнд ЧДЗДТГ-т оногдох хувийг хүлээн авсан өдрөөс эхэлнэ. ЧДЗДТГ-т оногдох хувийг хүлээн авахаас өмнө НҮБХХ-ийн зүгээс тус төслийн үйл ажиллагааг эхлүүлэхгүй.
2. Хэрэв урьдчилан төсөөлөөгүй зардал (инфляц, валютын ханшийн хэлбэлзэл болон бусад гэнэтийн хүчин зүйлс) гарсан буюу гарах нөхцөл бүрэлдсэн бол НҮБХХ цаашид нэмэлт санхүүжилт хийх шаардлагатай болсон талаарх тооцоог ЧДЗДТГ-т цаг тухайд нь хүргүүлнэ. ЧДЗДТГ нь шаардлагатай нэмэлт санхүүжилтийг НҮБХХ-т шилжүүлэхийн төлөө бүх талын хүчин чармайлт гаргана.
3. Дээрх 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад заасан төлбөрийн хуваарийн дагуу ЧДЗДТГ-т оногдох хувийг шилжүүлээгүй эсхүл дээрх 2 дахь заалтын дагуу шаардагдсан нэмэлт санхүүжилт ЧДЗДТГ-аас ирээгүй тохиолдолд энэхүү гэрээний дагуу НҮБХХ нь тус төслийн хүрээнд үзүүлэх тусламжийн хэмжээг бууруулах, түр зогсоох эсхүл цуцлах хүртэл арга хэмжээ авна.

5 дугаар зүйл

ЧДЗДТГ-т оногдох хувиас санхүүжүүлсэн тоног төхөөрөмж, бараа болон бусад эд хөрөнгийг өмчлөх эрх НҮБХХ-т төслийн хэрэгжилтийн хугацаанд олгогдох бөгөөд төсөл дууссаны дараа өмчлөлийг хоёр талын хамтарсан шийдвэрээр эцэслэнэ.

6 дугаар зүйл

ЧДЗДТГ-т оногдох санхүүжилтийг НҮБХХ-ийн санхүүгийн дүрэм, журам, дотоод бодлого болон үйл ажиллагааны дэгийн дагуу дотоод болон гадаад аудитад хамруулна.

7 дугаар зүйл

ЧДЗДТГ-аас НҮБХХ-т хүсэлт гаргасан тохиолдолд НҮБХХ нь өөрийн дотоод дүрэм, журамын дагуу санхүүгийн болон бусад төрлийн тайланг бэлтгэн илгээнэ.

8 дугаар зүйл

1. НҮБХХ нь төслийн баримт бичиг (Prodoc)-ийн дагуу "Нарны Илч" төсөлтэй холбоотой бүх арга хэмжээ хэрэгжиж дууссаныг ЧДЗДТГ-т мэдэгдэнэ.
2. "Нарны Илч" төслийн төлөвлөгөөт үйл ажиллагаа хэрэгжиж дууссаныг үл харгалзан НҮБХХ нь ЧДЗДТГ-ын санхүүжилтээр хэрэгжүүлсэн арга хэмжээтэй

холбоотойгоор үүссэн бүх санхүүгийн үүрэг хариуцлагыг биелүүлж дуусгах хүртэл ЧДЗДТГ-аас ирсэн ашиглагдаагүй байгаа мөнгөн хөрөнгийг буцаахгүй.

3. Хэрэв ЧДЗДТГ-аас ирсэн мөнгөн хөрөнгө дээрх санхүүгийн үүрэг хариуцлагыг биелүүлж дуусахад хүрэлцэхгүй бол НҮБХХ нь энэ талаар ЧДЗДТГ-т мэдэгдэж, хэрхэн төлбөр тооцоог дуусгах талаар ЧДЗДТГ-тай зөвлөлдөнө.
4. Төслийн баримт бичгийн дагуу төсөл хэрэгжиж дуусах үед санхүүгийн бүх үүрэг хариуцлага, төлбөр тооцоо хийгдэж дууссаны дараа 5,000 ам.доллар (таван мянга) хүрэхгүй хэмжээний төсөв зарцуулагдаагүй үлдсэн тохиолдолд НҮБХХ өөр зориулалтаар зарцуулахаар хуваарилна. Хэрэв санхүүгийн бүх үүрэг хариуцлага, төлбөр тооцоо хийгдэж дууссаны дараа 5,000 ам.доллар (таван мянган ам.доллар)-аас их үлдэгдэл байвал НҮБХХ нь ЧДЗДТГ-тай зөвшилцсөний үндсэн дээр тус төсвийг хуваарилна.

9 дүгээр зүйл

Талууд авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авах нь чухал болохыг зөвшөөрөв. Үүний тулд НҮБХХ талаас НҮБ-ын ажилтнуудын дүрэм, НҮБХХ-ийн Санхүүгийн дүрэм, НҮБ-ын Худалдан авах ажиллагааны гарын авлагад тусгагдсаны дагуу, өөрийн ажилтнуудын баримтлах ёстой ёс зүйн хэм хэмжээг өндөр байлгаж, гэрээт ажил, буцалтгүй тусламж болон бусад тэтгэмжийг зохицуулахтай холбоотой авлигын гэмт хэргээс сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл

НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн S/RES/1269 (1999), S/RES 1368 (2001), S/RES/1373 (2001) тоот зэрэг тогтоолын дагуу хандивлагч болон НҮБХХ нь терроризм, мөн терроризмын санхүүжүүлэлтийн эсрэг олон улсын тэмцлийг тууштай дэмжих үүрэг хүлээнэ. НҮБХХ-ийн бодлого нь терроризмтой холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг дэмжихэд шууд болон шууд бус байдлаар хөрөнгө ашиглагдахгүй байх байдлыг хангахад чиглэгдэнэ. Тус бодлогын дагуу, НҮБХХ нь энэхүү гэрээний хүрээнд хандивлагчаас авсан мөнгөн хөрөнгө терроризмтой холбоотой аливаа хувь хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх ямар нэгэн боломжгүй байх талаар зохих арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

11 дүгээр зүйл

1. Энэхүү гэрээний талууд хоорондоо зөвлөлдсөний дараа, “Нарны илч” төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүссэн бүх санхүүгийн үүрэг хариуцлагыг биелүүлж дуусахад хангалттай санхүүжилт ЧДЗДТГ-ын зүгээс болон бусад эх үүсвэрээс цугларсан байгаа нөхцөлд НҮБХХ эсхүл ЧДЗДТГ зүгээс энэхүү гэрээг дуусгавар болгож болно. Аль нэг тал гэрээг дуусгавар болгох тухай шийдвэрийг нөгөө талдаа бичгээр мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дараа гэрээ хүчингүй болно.
2. Хэрэв “Нарны Илч” төслийн үлдэгдэл хөрөнгө ЧДЗДТГ-т оногдох хувиар санхүүжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүлээсэн санхүүгийн үүрэг

хариуцлагыг биелүүлэхэд хангалтгүй бол НҮБХХ энэ талаар ЧДЗДТГ-т мэдэгдэж, хүлээсэн үүрэг, хариуцлагыг хэрхэн биелүүлэх арга замын талаар зөвлөлдөнө.

3. Энэхүү гэрээг цуцалсныг үл харгалзан НҮБХХ нь ЧДЗДТГ- т оногдох хувиар санхүүжүүлсэн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүссэн бүх санхүүгийн үүрэг хариуцлагыг дуусгах, мөн эдгээр арга хэмжээг зүй ёсоор гүйцэтгэж дуусах хүртэл ЧДЗДТГ-т оногдох хувиас ашиглагдаагүй үлдэгдэл мөнгөн дүнг НҮБХХ үргэлжлүүлэн эзэмшинэ.
4. Хэрэв төслийг хэрэгжүүлж дуусахаас өмнө энэхүү гэрээ цуцлагдсан бол НҮБХХ нь санхүүгийн бүх үүрэг хариуцлагаа биелүүлж дууссаны дараа 5,000 ам.доллар (таван мянган ам.доллар) хүрэхгүй хэмжээний мөнгө дүн зарцуулагдаагүй үлдсэн тохиолдолд тус мөнгийг НҮБХХ өөр зорилгод шууд хуваарилан ашиглана. Бүх санхүүгийн үүрэг хариуцлагаа биелүүлсний дараа НҮБХХ-т 5,000 ам.доллар (таван мянган ам.доллар)-аас дээш хэмжээний мөнгөн дүн зарцуулагдаагүй үлдсэн бол ЧДЗДТГ-тай зөвшилцсөний үндсэн дээр дахин хуваарилна.

12 дугаар зүйл

(а) НҮБХХ болон ЧДЗДТГ хооронд мэдэгдэл болон захидал харилцааг дараах хаягаар солилцоно.

ЧДЗДТГ-т:

Мандуул Нямандэлэг,

Чингэлтэй дүүргийн засаг дарга

Хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн нутгийн захиргааны III байр.

(b) Санхүүжилтийг хүлээн авсны дараа НҮБХХ ЧДЗДТГ-т доорх цахим шуудангаар НҮБХХ санхүүжилтийг хүлээн авсан болохыг баталгаажуулсан цахим баримт илгээнэ.

ЧДЗДТГ-ын цахим шуудан: manduuln@chingeltei.gov.mn

Хүлээж авах ажилтан: Мандуул Нямандэлэг, Чингэлтэй дүүргийн засаг дарга

(с) НҮБХХ-т: НҮБХХ-ийн Монгол дахь суурин төлөөлөгч, хатагтай Матилда Димовска

Хаяг:

Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байр, НҮБ-ын гудамж-14
Сүхбаатар дүүрэг,
14201 Улаанбаатар, Монгол Улс

13 дугаар зүйл

Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээнд сүүлд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр гэж тооцно.

Дээрхийг гэрчлэн зохих ёсоор гарын үсэг зурах эрх олгогдсон доорх төлөөлөгчид энэхүү гэрээний Англи, Монгол хэл дээрх хоёр эх хувьд гарын үсэг зурав. Гэрээг тайлбарлах явцад зөрөлдөөн гарах тохиолдолд Англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

ЧДЗДТГ-ыг төлөөлж:



Мандуул Нямандэлэг

Чингэлтэй Дүүргийн Засаг дарга
2025 оны 2-р сарын 12
Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн нутгийн захиргааны III байр

НҮБХХ-ийг төлөөлж:



Матилда Димовска

НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч
2025 оны 2-р сарын 12
Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байр, НҮБ-ын гудамж-14,
Сүхбаатар дүүрэг, 14201
Улаанбаатар, Монгол Улс

**FINANCING AGREEMENT BETWEEN THE UNITED NATIONS
DEVELOPMENT PROGRAMME AND THE GOVERNOR'S OFFICE OF
CHINGELTEI DISTRICT**

WHEREAS the United Nations Development Programme (hereinafter referred to as "UNDP") and the Governor's Office of the Chingeltei district (hereinafter referred to as the "Governor's Office") have agreed to co-operate in the implementation of a project in Mongolia (hereinafter referred to as "the Project"), as described in the Project document "Solar Facility", in Mongolia, and submitted to the Governor's Office for information.

WHEREAS Governor's Office has informed UNDP of its willingness to contribute funds (hereinafter referred to as "the contribution") to the UNDP on a cost-sharing basis to increase the resources available for the Solar Facility;

WHEREAS the UNDP shall designate an Implementing Partner for the implementation of each project financed from the contribution (hereinafter referred to as "the Implementing Partner")

NOW THEREFORE, UNDP and the Governor's Office hereby agree as follows:

Article I

1. Governor's Office shall, in the manner referred to in paragraph 2 of this Article, place at the disposal of UNDP the contribution of **1,028,400,000 MNT** [one billion twenty-eight million four hundred thousand], which is equivalent to **300,000 USD** [three hundred thousand] as per UN operational exchange rate as of 01 February 2025.
2. The Governor's Office shall, in accordance with the schedule of payments set out below, deposit the contribution in

Trade & Development Bank of Mongolia
Enkhtaiwan branch
Tugrik account №404001574

Date payment due

Amount (stated currency)

(a) 15 March 2025

1,028,400,000 MNT

3. The Governor's Office will inform UNDP when the Contribution is paid via en e-mail with remittance information to contributions@undp.org, providing the following information: Governor's Office, UNDP country office, "Solar Facility". This



information should also be included in the bank remittance advice when funds are remitted to UNDP.

4. The value of the payment, if made in a currency other than United States dollars, shall be determined by applying the United Nations operational rate of exchange in effect on the date of payment. Should there be a change in the United Nations operational rate of exchange prior to the full utilization by the UNDP of the payment, the value of the balance of funds still held at that time will be adjusted accordingly. If, in such a case, a loss in the value of the balance of funds is recorded, UNDP shall inform the Governor's Office with a view to determining whether any further financing could be provided by the Governor's Office. Should such further financing not be available, the assistance to be provided to the "Solar Facility" project may be reduced, suspended or terminated by UNDP.
5. The above schedule of payments takes into account the requirement that contributions shall be paid in advance of the implementation of planned activities. It may be amended to be consistent with the progress of project delivery. UNDP shall not absorb any loss (including but not limited to exchange fluctuations) under the Project. The Parties acknowledge and agree that all losses shall be charged to the Project.
6. All financial accounts and statements shall be expressed in United States dollars.
7. UNDP may agree to accept Contributions in a currency other than United States dollars provided such currency is fully convertible or readily usable by UNDP and subject to the provisions of paragraph 6 above. Any change in the currency of the Contribution shall be made only in agreement with UNDP.

Article II

1. In accordance with the decisions and directives of UNDP's Executive Board reflected in its Policy on Cost Recovery from Other Resources, the Contribution shall be subject to cost recovery for indirect costs incurred by UNDP headquarters and country office structures in providing General Management Support (GMS) services. To cover these GMS costs, the contribution shall be charged a fee equal to 5%. Furthermore, as long as they are unequivocally linked to the specific project(s), all direct costs of implementation, including the costs of implementing partner, will be identified in the project budget against a relevant budget line and borne by the project accordingly.
2. The aggregate of the amounts budgeted for the project, together with the estimated costs of reimbursement of related support services, shall not exceed the total resources available to the project under this Agreement as well as funds which may be available to the project for project costs and for support costs under other sources of financing.

Article III

ТАГ АА
ТБ
АН
С
ТАХТ

1. The contribution shall be administered by the UNDP in accordance with UNDP regulations, rules, policies and procedures, applying its normal procedures for the execution of its projects.
2. Project management and expenditures shall be governed by the regulations, rules, policies and procedures of UNDP and, where applicable, the regulations, rules, policies and procedures of the Implementing Partner.

Article IV

1. The implementation of the responsibilities of the UNDP and of the Implementing Partner pursuant to this Agreement and the relevant project document shall be dependent on receipt by the UNDP of the contribution in accordance with the schedule of payments set out in Article I, paragraph 2, above. UNDP shall not start implementation of the activities prior to receiving the Contribution.
2. If unforeseen increases in expenditures or commitments are expected or realized (whether due to inflationary factors, fluctuation in exchange rates or unforeseen contingencies) UNDP shall submit to the Governor's Office on a timely basis a supplementary estimate showing the further financing that will be necessary. The Governor's Office shall use its best endeavors to make available to UNDP the additional funds required.
3. If the Contribution referred to in Article I, paragraph 2, above, are not received in accordance with the payment schedule, or if the additional financing required in accordance with paragraph 2, above, is not forthcoming from the Governor's Office or other sources, the assistance to be provided to the Project under this Agreement may be reduced, suspended or terminated by UNDP.

Article V

Ownership of equipment, supplies and other property financed from the contribution shall vest in UNDP. Matters relating to the transfer of ownership by UNDP shall be determined in accordance with the relevant policies and procedures of UNDP.

Article VI

The contribution shall be subject exclusively to the internal and external auditing procedures provided for in the financial regulations, rules, policies and procedures of UNDP.

Article VII

UNDP shall provide the Governor's Office on request with financial and other reports prepared in accordance with UNDP reporting procedures.

Article VIII

1. UNDP shall notify the Governor's Office when all activities relating to the "Solar Facility" project have been completed in accordance with the Prodoc.
2. Notwithstanding the completion of all activities relating to the "Solar Facility" project, UNDP shall continue to hold unutilized funds from the Contribution until all commitments and liabilities incurred in implementation of the activities finance by the contribution have been satisfied and these activities brought to an orderly conclusion.
3. If the unutilized funds prove insufficient to meet such commitments and liabilities, UNDP shall notify the Governor's Office and consult with the Governor's Office on the manner in which such commitments and liabilities may be satisfied.
4. In cases where the Project is completed in accordance with the project document any funds below 5,000 USD (five thousand US Dollars) that remain unexpended after all commitments and liabilities have been satisfied shall be automatically reallocated by UNDP. Any funds above 5,000 USD (five thousand US Dollars) that remain unexpended after all commitments and liabilities have been satisfied shall be reallocated by UNDP after consultation with the Governor's Office.

Article IX

The Parties agree that it is important to take all necessary precautions to avoid corrupt practices. To this end, UNDP shall maintain standards of conduct to govern the performance of its staff, including of corrupt practices in connection with the award and administration of contracts, grants, or other benefits, as set forth in the Staff Regulations and Rules of the United Nations, the UNDP Financial Regulations and Rules, and the UND Procurement Manual.

Article X

Consistent with numerous United Security Council resolutions, including S/RES/1269 (1999), S/RES 1368 (2001), and S/RES/1373 (2001), both the Donor and UNDP are firmly committed to the international fight against terrorism, and in particular, against the financing of terrorism. It is the policy of UNDP to seek to ensure that none of its funds are used, directly or indirectly, to provide support to individuals or entities associated with terrorism. In accordance with this policy, UNDP undertakes to use reasonable efforts to ensure that none of the Donor funds provided under this Agreement are used to provide support to individuals or entities associated with terrorism.

Article XI

1. After consultations have taken place between the two Parties to this Agreement and provided that the funds from the Contribution already received are, together with other funds available to the "Solar Facility" project, sufficient to meet all commitments and liabilities incurred in the implementation of the "Solar Facility" project, this Agreement may be terminated by UNDP or by the Governor's Office. The Agreement shall cease to be in force thirty days after either of the Parties may have given notice in writing to the other Party of its decision to terminate the Agreement.
2. If the unutilized contribution-payments, together with other funds available to the "Solar Facility" project, are insufficient to meet such commitments and liabilities, UNDP shall notify the Governor's Office and consult with the Governor's Office on the manner in which such commitments and liabilities may be satisfied.
3. Notwithstanding termination of this Agreement, UNDP shall continue to hold unutilized funds until all commitments and liabilities incurred in implementation of the activities financed by the contribution have been satisfied and these activities brought to an orderly conclusion.
4. In cases where this agreement is terminated before Project completion any funds below 5,000 USD (five thousand US Dollars) that remain unexpended after all commitments and liabilities have been satisfied shall be automatically reallocated by UNDP. Any funds above 5,000 USD (five thousand US Dollars) that remain unexpended after all commitments and liabilities have been satisfied shall be reallocated by UNDP after consultation with the Governor's Office.

Article XII

Any notice or correspondence between UNDP and the Governor's Office will be addressed as follows:



(a) To Governor's Office:

Address:

Manduul Nyamandeleg

Governor of Chingeltei district

3rd place, Sambuu's street, Fourth khoroo, Chingeltei District, Mongolia

(b) Upon receipt of funds, UNDP shall send an electronic receipt to the Governor's Office email address provided below as confirmation that the remitted funds have been received by UNDP

Governor's Office email address: _ manduuln@chingeltei.gov.mn _____

Attention:

_____ Manduul Nyamandeleg, Governor of Chingeltei district _____

(c) To UNDP: Ms Matilda Dimovska, Resident Representative of UNDP in Mongolia

Address:

United Nations Development Programme in Mongolia
UN House, UN Street – 14
Sukhbaatar district, Ulaanbaatar – 14201

Article XIII

This Agreement shall enter into force upon the signature of this Agreement by parties hereto, on the date of the last signature.

IN WITNESS WHEREOF, the undersigned, being duly authorized thereto, have signed the present Agreement in the English and Mongolian languages in two copies. The English version will prevail for interpretation purposes in cases of discrepancy.

For Governor's Office:



Manduul Nyamandeleg
Governor of Chingeltei district
12 February 2025
Ulaanbaatar, Mongolia

For the United Nations Development Programme



Matilda Dimovska
UNDP Resident Representative
12 February 2025
Ulaanbaatar, Mongolia